



APiP

Азия Пасифик Пропертиз ХК

2013 оны 06 сарын 27 -ны өдөр

№ 25

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Компанийн гүйцэтгэх захирлыг
үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай:*

Компанийн тухай хуулийн 76.1.8 дахь заалт, ТУЗ-ийн дарга Ли Майкл Кашеллын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн 2013 оны хоёрдугаар хуралд оролцсон 6 гишүүний 66.6 хувийн саналтайгаар Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд ажиллаж байсан Баярмагнай овогтой Баттулгыг 2013 оны 06 сарын 13-ны өдрөөр тасалбар болгон албан тушаалаас чөлөөлсүгэй.
2. Гүйцэтгэх захиралтай холбоотой баримт бичгийг Монголын Хөрөнгийн бирж ТӨХК, ҮЦГТТХТ ХХК, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж өөрчлөлтийг мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Булгантамирт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ



Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

Оффисийн байр ОХУ-ын Восточный Район - 399-0000

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох тухай:

Компанийн тухай хуулийн 78.1 дэх хэсэг, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн 2013 оны хоёрдугаар хуралд оролцсон 6 гишүүний 66,6 хувийн саналтайгаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Ли Майкл Кашелл-ыг сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-ийг удирдан зохион байгуулж ажиллахыг Ли Майкл Кашелл-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ
Б.ЦЭНДСҮРЭН
Э.ОДБАЯР
Б.БЯМБАЖАВ
Б.АЮУШ
Д.НАМСРАЙЖАВ



APiP

Азия Пасифик Пропертис ХК

2013 оны 06 сарын 27 -ны өдөр

№ 27

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох тухай:

Компанийн тухай хуулийн 76.1.8 дахь хэсэг, ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн 2013 оны хоёрдугаар хуралд оролцсон 6 гишүүний 66,6 хувийн саналтайгаар Компанийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Дангаасүрэн овогтой Галбадрахыг 2013 оны 06 сарын 27-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлэн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийг төлөөлж гарын үсэг зурахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ли Майкл Кашелл-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон хөлсөөр ажиллах гэрээнд заасан чиг үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Д.Галбадрах-д үүрэг болгосугай.
4. Шинээр сонгогдсон Гүйцэтгэх захиралтай холбоотой баримт бичгийг Монголын Хөрөнгийн бирж ТӨХК, ҮЦТГТХТ ХХК, Санхүүгийн Зохицуулах Хороо, Улсын бүртгэлийн албанд хүргүүлж өөрчлөлтийг мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Э.Булгантамирт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ

Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

Сүхбаатар замын 16, Рамонан Бизнес-кафе 999-0000



APiP

Азиa Пасифик Прoпeртиc ХК

2013 оны 06 сарын 27 -ны өдөр

№ 28

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн ТУЗ-ийн хороодыг байгуулах тухай:

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь заалтыг удирдлага болгон компанийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодыг байгуулсугай.

1. Аудитын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Аюуш, ТУЗ-ийн дарга Ли Майкл Кашелл, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Бямбажав нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар Б.Аюушыг
2. Цалин урамшууллын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ариунболор, ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Цэндсүрэн, ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Олбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар Б.Ариунболорыг
3. Нэр дэвшүүлэх хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Намсрайжав, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Галбадрах, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, даргаар Д.Намсрайжавыг тус тус томилсугай.
4. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, хороодын үйл ажиллагааны журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг Хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ

Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

Өмнөд талд 16-р байртай 999-р тоот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн сонгох тухай:

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7. дахь заалт, Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

“Азиa Пасифик Пропертиc” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүн Б.Баттулга өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул ТУЗ-ийн хараат гишүүнд

1. ТУЗ-ийн 2013 оны хоёрдугаар хуралд оролцсон 6 гишүүний 66,6 хувийн саналтайгаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат гишүүнээр Чимэддорж овогтой Энхбаярыг сонгосугай.
2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, журмаар тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ТУЗ-д ажиллахыг Ч.Энхбаяр-т үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ